

НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН  
 ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТИЙГ ЗОХИОН БАЙГУУЛСАН  
 АЖЛЫН 2021 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН 01-НИЙ ӨДРӨӨС 10 ДУГААР САРЫН 25-НЫ ӨДӨР  
 ХҮРТЭЛХ ТАЙЛАН

2021.10.25

Улаанбаатар хот

Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газарт 2021 оны 01-р сарын 01-ний өдрөөс 10-р сарын 25-ны өдөр хүртэлх байдлаар 134 өргөдөл, гомдол албан хаагчид болон иргэд, ААН-ээс бичгээр ирүүлснийг хүлээн авч үүнээс 131 өргөдөл гомдлыг “Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлыг шийдвэрлэх тухай хууль”-ийн дагуу шийдвэрлэж, 3 өргөдөл гомдол нь судлагдаж байна.

**Өргөдөл гомдлын төрөл:**

- Түрээсийн гэрээ, түрээсийн төлбөртэй холбоотой 48
- Тээврийн хэрэгслийн дуудлага худалдаатай холбоотой 17,
- Архивын лавлагаа, мэдээлэл хүссэн 13
- Тэтгэвэр тэтгэмж, тусламж олгох, ажлаас чөлөө хүсэх, ажлаас чөлөөлөгдөх зэрэг хүний нөөцтэй холбоотой 25
- Бусад 31

**Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн байдал:**

Д/Д	Хэлтэс	Шийдвэрлэлт			Нийт	Шийдвэрлэлтийн хувь
		Шийдвэрлэгдсэн	Судлагдаж байгаа	Хугацаа хэтэрч шийдвэрлэсэн.		
1	Удирдлага	1	-	-	-	100
2	Захиргаа санхүүгийн хэлтэс	72	1	-	73	98,6%
3	Өмчийн бүртгэл, хувьчлалын хэлтэс	9	-	-	-	100%
4	Өмчийн төлөөлөл, менежментийн хэлтэс	9	1	-	10	90%
5	Өмчийн мэдээлэл хяналт, ашиглалтын хэлтэс	40	1	-	41	97,5%
	Нийт	131	3	-	134	97,7%

Судлагдаж байгаа 3 өргөдөл гомдлын тухайд:

- Хугацаа дуусахад 3 хоног үлдсэн 1 өргөдөл (ӨТМХ) Иргэн Э.Декабрь 2015 онд “Улаанбаатар сан” ОНӨААТҮГ-д ажилласан цалин 5,724,501 нөхөж олгуулах талаар.
- Хугацаа дуусахад 23 хоног үлдсэн 1 өргөдөл (ЗСХ) Албан хаагч Н.Төрболд сургалтын төлбөрт дэмжлэг хүсэх талаар.
- Хугацаа дуусахад 23 хоног үлдсэн 1 өргөдөл (ӨМХАХ) Иргэн С.Энхболд “Үдийн цай” хөтөлбөрийг хэрэгжүүлэгч цайны газрын түрээслэгчийн сонгон шалгаруулалтын талаарх гомдол.

**Шийдвэрлэхэд хугацаа шаардагдсан өргөдөл гомдлууд:**

- Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Д.Сумъяабазар-т гаргасан иргэн Ж.Эрдэнэцэцэгийн хуваарилсан байраа авч чадаагүй тухай хүсэлт нь НӨАУГ-т хугацаа дуусахад 9 хоног дутуу үедээ шилжиж ирсэн бөгөөд 30 хоногоор сунгуулан хүсэлт гаргасан иргэнтэй холбогдож хүсэлтийн дагуу Баянгол дүүргийн ЗДТГТ-т 2020 оны 4/1688, 2021 оны 4/432 дугаар бүхий албан бичгээр байрыг чөлөөлөн яаралтай хүлээлгэн өгөх тухай, НЗДТГ-т 2021 оны 4/770 албан бичгээр БГД-ийн ЗДТГ нь тус орон сууцыг тайлан балансаас хасаж хүлээлгэн өгөх нь зүйтэй байх тул холбогдох арга хэмжээг авч ажиллах талаар үүрэг, чиглэл өгөх хүсэлтийг хүргүүлсэн.

ӨМХАХ-ийн ахлах мэргэжилтэн Ж.Сувданзаяа 47 хоногт шийдвэрлэсэн.

- 2021 оны 07 дугаар сарын 26-ны өдөр ирсэн "Бага Хандгайт" ахмадын амралтын газрын удирдлагын талаар гомдол гаргах тухай иргэн Р.Ёндон-ийн хүсэлтийн дагуу "Бага Хандгайт" ОНӨААТҮГ-ын удирдлага, санхүүтэй холбогдох оролдлогыг удаа дараа хийсэн ч амжилтгүй болсон тул өргөдөл гомдлын хугацааг 30 хоногоор сунгуулан СБД ЗДТГ-т "Бага Хандгайт" ахмадын амралтын газрын үйл ажиллагаа, манайд ирүүлсэн гомдлын дагуу тайлбар ирүүлэх тухай 2021 оны 08 сарын 27-ны өдрийн 2/1055 тоот албан бичгээр хүсэлт явуулсан бөгөөд хариу ирж 09 дүгээр сарын 20-ны өдрийн 3/1320 тоот албан бичгээр хариуг өгсөн.

ӨТМХ-ийн Өмчийн төлөөлөл хариуцсан мэргэжилтэн Э.Анударь 58 хоногт шийдвэрлэсэн.

**Өргөдөл гомдол шийдвэрлэсэн байдлын тайлан:**

Ангилал		
Иргэний талд шийдвэрлэсэн	Боломжгүй тухай хариу өгсөн	Бусад
82	19	30

**Газрын өргөдөл гомдол шийдвэрлэлтийн дундаж хугацаа 8 хоног 6 цаг 19 минут байна (131 өргөдөл). Үүнийг хэлтэс бүрээр харуулбал:**

Хэлтэс	Нийт өргөдөл гомдол	Шийдвэрлэлтийн дундаж хугацаа
Захиргаа, санхүүгийн хэлтэс	72	8 хоног 1 цаг 54 минут
Өмчийн бүртгэл, хувьчлалын хэлтэс	9	5 хоног 16 цаг 37 минут
Өмчийн төлөөлөл, менежментийн хэлтэс	9	15 хоног 6 цаг 25 минут
Өмчийн мэдээлэл, хяналт ашиглалтын хэлтэс	40	10 хоног 11 цаг 33 минут

**Өргөдөл гомдол шийдвэрлэлтийн дундаж хугацааг сараар харьцуулбал:**

